



МАХН-ЫН ОНЦ ИХ ХУРАЛ БУЮУ ХХ ЗУУНЫ МОНГОЛЧУУДЫН УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫН АСУУДАЛД

(Улс төрийн боловсролын асуудлыг нэхэн сөхөхүйд)

Н.Батсүмбэрэл
МУБИС-ийн Улс төр судлалын докторант

Резюме: 25 лет назад-с 10 по 13 апреля 1990 года состоялся Чрезвычайный съезд Монгольской народно-революционной партии (МНРП), именуемой теперь Монгольской Народной партией (МНП). Съезд явился единственным Чрезвычайным съездом в 94-летней истории МНП до настоящего времени. Данный съезд партии следует отметить не как экстренное заседание, а как историческое событие, которое ускорило процесс модернизации, активировало трансформацию в социальной, политической, экономической и духовной сфере страны, а также дало новое начало по связям с общественностью и политической среде. В ходе пересмотра документов конференции, и связанных с ними материалов 25 летней давности, данные выводы становились все более очевидными, в том, что они являются проверенной временем исторической инновацией, обхватывающей всю страну.

Түлхүүр үг: онц их хурал, төв хороо, ардчилал, үзэл суртал, манлайлал

Нэг. Онц их хурлын урьдач нөхцөлийн тухайд:

Түүхэнд ганцхан удаа хуралдсан онц их хурлыг нэг л өдөр зарлаад шууд хуралдуулчихаагүй. Харин тус их хурлыг хуралдуулах зайлшгүй суурь нөхцөлүүд хэдэн жилийн өмнөөс тавигдаж, 1989 оны сүүлч болон 1990 оны эхэн үеийн улс төрийн дараалсан эрчимтэй өрнөлүүд байдлыг хурдасгажээ. Онц их хурлын өмнө болж өнгөрсөн үйл явдлууд ар араасаа уялдан

холбогдох ба түүнийг хэлхэн эргүүлбээс эрхгүй сонирхол татна. Энэ цаг үед дэлхий дахинаа ялангуяа хуучин социалист системийн орнуудад болж байсан өөрчлөн байгуулалтын салхи, системийн тэргүүлэгч тухайн үеийн ЗХУ-д болж байсан үйл явдлууд, монголын дотоодод өрнөсөн улс төрийн алхамуудаас гадна тэр үеийн МАХН-ын удирдлагуудын “нам ба төрийг зааглах, намаа шинэчлэх, улс орондоо өөрчлөлтийг эхлүүлэх” бодлого, санаачлагыг туйлаас дэмжсэн чин эрмэлзэл нь онц их хурал хуралдуулах чухал хүчин зүйлс болсон байна.

1980-аад оны дунд үеэс эхлэн намын бодлого, явуулж байгаа үйл ажиллагаа болон нам, төрийн удирдагчдыг шүүмжлэх өнгө аяс цухалзах болж, тухайн үеийн МАХН-ын дээд удирдлагын түвшинд ч намын ажил, арга барилдаа санал зөрөлдөх явдал гарч эхэлсэн байдаг. 1984 оны наймдугаар сард монголын нам, төрийг олон жил дараалан удирдаж байсан Ю.Цэдэнбалыг * эрүүл мэндийн шалтгаанаар бүх албан тушаалаас нь буулгаж, МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргаар Ж.Батмөнхийг ** сонгов. Түүнээс хоёр жилийн дараа буюу 1986 онд хуралдсан МАХН-ын XIX их хурал өмнөх их хурлуудаа

* Ю.Цэдэнбал – Увс аймагт 1916 онд төрсөн. 1952-1974 онд Сайд нарын Зөвлөлийн дарга буюу Ерөнхий сайд, 1974-1984 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга буюу Төрийн тэргүүнээр ажиллаж байсан. 1940-1954 болон 1958-1984 онуудад МАН (тэр үедээ МАХН нэртэй байсан)-ыг удирдаж байв.

** Ж.Батмөнх – Увс аймагт 1926 онд төрсөн. 1974-1984 онд Сайд нарын Зөвлөлийн дарга буюу Ерөнхий сайд, 1984-1990 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга буюу Төрийн тэргүүнээр ажиллаж байсан. 1984-1990 онд МАН (тэр үедээ МАХН нэртэй байсан)-ыг удирдаж байв.

бодвол санал шүүмжлэл илүү ихтэй, магтан сайшаалт багатай, нэлээд ажил хэрэгч болжээ. Тус их хуралд Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргын тавьсан “МАХН-ын Төв Хорооны тайлан, цаашдын зорилт” улс төрийн илтгэл ч намынхаа ажил, арга барилд сүрхий шүүмжлэлтэй хандаж, намын үйл ажиллагаагаа орчин үеийн шаардлагад хүргэх, үзэл суртлын өөрчлөлт хийх, намын ажил дахь онолын сэтгэлгээг хөгжүүлэх, улс төрийн системийн сургалтыг боловсронгуй болгох зэрэг асуудлыг тусгасан байдаг (Батмөнх, 1986). Түүнчлэн XIX их хурлын төлөөлөгчид “намаас улс орны нийгэм, аж ахуйн асуудалд хариуцлага муутай хандах боллоо”, “аймгуудын нам, төрийн байгууллагууд муу ажиллаж байна”, “нам улс төрийн үзэл сурталдаа үлбэгэр, сул дорой хандаж байна”, “нам, төрийн ажлын арга барил хоцрогдож байна”, “ажлын алдаа дутагдал гаргасан ч хариуцлагаас зугтаж байна”, “боловсон хүчний сонголтыг өнгөцөөр хийж байна” гэх зэргээр нам, төрийн байдлыг шүүмжилсэн байв.

XIX их хурлаас даруй хоёр, хоёр жилийн зайтай хуралдсан МАХН-ын Төв Хорооны V (1988 он) ба VIII (1990 он) бүгд хурлууд намын дотоод дахь шинэчлэлийн уур амьсгалыг илэрхий хөгжөөж, монголын ардчиллын үйл хэрэгт мөрөөгүн тод үлдээсэн юм. Төв Хорооны V бүгд хурлыг угтан намын үзэл суртал, зохион байгуулалтын талаар нийтийн хэлэлцүүлгийг хэвлэл мэдээлэл болон уулзалт, асуулгын бүхий л хэлбэрээр зохион байгуулсан байдаг. Тэрхүү хэлэлцүүлэгт намын гишүүд төдийгүй иргэд олон түмэн ч идэвхтэй оролцож, нам болон төрийн ажлын алдаа дутагдлыг шүүмжилж, улс төрийн ардчилал, эдийн засгийн шинэчлэл, оюун санааны эрх чөлөөг хүчтэй шаарджээ. Намын Төв Хороо ч хэлэлцүүлгийн үр дүнг чухлаар үзэж, бүгд хурлын шийдвэрт нийгмийн өөрчлөн байгуулалтыг эрчимжүүлэх асуудлыг тусгаж, 1988 оны наймдугаар сард “Хэвлэл, утга зохиолыг хянах газар”-ыг татан буулгав. Тус газрыг татан буулгаснаар хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, зохиолчид, зураачид зэрэг уран бүтээлчдийн

чөлөөтэй сэтгэх, зоригтой бүтээн туурвих боломжийг бүрдүүлээд зогсохгүй энэ нь эрдэм шинжилгээний ажилтнууд, багш, оюутнуудад оюун санааны сэргэлт болсон гэдгийг судлаачид онцолсон байдаг. МАХН-ын өөрийнх нь дуу хоолой болсон “Үнэн” сонин ч төр, нам, улс төрийн үйл хэрэгт үзэл бодлын чөлөөт байдлыг илэрхийлж, шүүмжлэлт санал, нийтлэлүүдийг гаргаж эхэлсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

МАХН-ын Төв Хорооноос намынхаа программ (мөрийн хөтөлбөр), дүрэм, БНМАУ-ын Үндсэн хуулийг шинэчлэх ажлыг эхлүүлжээ. Тодруулбал, 1987 оны тавдугаар сард “МАХН-ын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулалтын төсөл боловсруулах комисс”, 1989 оны хоёрдугаар сард “МАХН-ын программыг шинэчлэн найруулах комисс”-ыг тус тус байгуулан ажиллуулж 1990 оны хоёрдугаар сард “МАХН-ын дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл”-ийг хэвлэлд нийтлүүлж байв. Намаас байгуулсан дээрх комиссын зэрэгцээгээр МАХН-ын гишүүн голдуу 15 судлаач эрдэмтэн * нийлж МАХН-ын Программ, Дүрмийн төслийг боловсруулсан байна. Тэдний бэлтгэсэн төслийг МАХН-ын Улс Төрийн Товчооны өргөтгөсөн хурлаар хэлэлцэж, 1990 оны гуравдугаар сарын 8-ны өдөр намын төв хэвлэл болох “Үнэн” сонинд нийтлэжээ. Тэрхүү 15 судлаач эрдэмтдийн нэг, тухайн үедээ МАХН-ын хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байсан доктор, профессор Ж.Ядамсүрэнгийн ** “Бидний боловсруулсан баримт бичгийг өнөөдрийн цаг хугацаанаас харахад дутуу дулимаг зүйл, буруу зөрүү ойлголт, оновчтой биш тодорхойлолт харагддаг. Тэр үед зөвхөн формацийн онолоор нийгмийн хөгжлийг авч үздэг, төсөөлж байсан нийгмээ нүдээрээ хараагүй, юмны нарийн ширийнийг сайн ялгаж салгаж чаддаггүй байсан, тэр үеийн үйл явц бидний бодож байснаас эрч далайцтай, хавьгүй хурдтайгаар өрнөсөн

* 1989 оны сүүлчээр цуглаж ажилласан 15 эрдэмтний 14 нь МАХН-ын гишүүн байжээ.

** Ж.Ядамсүрэн – МАН (тухайн үедээ МАХН нэртэй байсан)-ын хэлтсийн орлогч эрхлэгч, эрхлэгч, 1991 оноос Улаанбаатар хотын намын хорооны дарга, 1992 оноос МАХН-ын Нарийн бичгийн даргаар ажиллаж байв.



зэрэгтэй холбоотой. Гэвч бидний ажил түүхийн тухайн үеийн үйл явцад том түлхэц болсон” *** гэж хэлсэн нь тэдгээр эрдэмтэн судлаачдын үйл хэргийг оновчтой дүгнэсэн гэж хэлж болно. Тэд “Иж бүрэн шинжтэй өөрчлөлт хэрэгтэй” гэсэн гарчиг бүхий ил захидлыг МАХН-ын Төв Хороонд гаргасны дотор намын онц их хурлыг яаралтай хуралдуулахыг мөн шаардсан байв.

Хэвлэл, утга зохиолыг хянах газрыг байхгүй болгосны үр дүнд улс төрийн ардчилал, эдийн засгийн өөрчлөлт, оюун санааны эрх чөлөөг эрэлхийлсэн үйл явц улам хүчээ авч, багш, оюутан, уран бүтээлчдийн элдэв дугуйлан, клуб, бүлгэм олноор бий болж, түүнээс зохион байгуулах төрөл бүрийн хэлэлцүүлэг, уулзалт, зөвлөгөөн, цуглаануудаар хүрээгээ тэлсээр байв. Улаанбаатар хот болон Ховд аймагт нийтийг хамарсан цуглаан болж, эдгээрээс чухал байр суурь эзлэх үйл явц нь 1989 оны арван нэгдүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд Нийслэл хотноо болсон Залуу уран бүтээлчдийн улсын II зөвлөгөөн юм. Энэ зөвлөгөөнөөс залуучуудын бие даасан чөлөөт байгууллага байгуулах санаачлага урган гарсан нь Монголын Ардчилсан Холбоо (МоАХ) болсон байна. МоАХ-г байгуулснаа зарласан 1989 оны арван хоёрдугаар сарын 10-ны өдрийн цуглаанаас тухайн үеийн нам, төрийн удирдлагад илгээсэн өргөх бичгийн агуулга нь урьд өмнө болсон цуглаан, зөвлөгөөний утга санааг уламжлан хөгжөөсөн байдаг.

Нийгмийн өөрчлөлтийг түргэтгэх гэсэн нам доторх болон намын гаднах байгууллага, гишүүд, олон түмний шаргуу санаачлагын зэрэгцээгээр тэр үеийн МАХН, түүний удирдлагууд цаг үеийн шинэчлэлийг дэмжиж байсан нь 1990 оны гуравдугаар сарын 12-аас 14-ний өдрүүдэд хуралдсан намын Төв Хорооны VIII бүгд хурлаас илэрхий харагддаг. Энэ бүгд хурал дээр Ж.Батмөнх тэргүүтэй улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон юм. Уг явдлыг “Ийм нөхцөлд ард түмний амгалан

тайван байдал, үндэсний эв нэгдлийг хамгаалах, хүмүүнлэг ёсыг эрхэмлэх, улс төрийн тогтвортой байдлыг хангах эрх ашгийн үүднээс Улс төрийн товчоо, нарийн бичгийн дарга нар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрохоор санаачилсан нь цаг үеийн байдлыг зөв тусгасан шийдвэр байв” гэж бүгд хурлын тогтоолд дүгнэсэн байна. Намын Төв Хорооны хурлуудын шийдвэрийг хангалттай хэрэгжүүлээгүй, МАХН-ын эхлүүлсэн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд идэвхтэй байр суурь илэрхийлэн ажиллаагүй, ажлын хуучирсан арга барилаас салж чадаагүй зэргээр өөрсдийгөө буруутгаж санаачлагаараа огцорсон намын хуучин удирдлагуудын оронд шинэ удирдлагыг сонгохдоо тухайн үед хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байсан Г.Очирбатыг * Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргаар сонгож, өөрчлөлт шинэчлэлийн үйл явцтай нийцүүлэн намаа шинэчлэх үүргийг түүний багт хүлээлгэжээ.

Тус бүгд хурлаас БНМАУ-ын Үндсэн хуулийн оршил болон 82 дугаар зүйлд байсан МАХН нь төр, нийгмийг удирдан жолоодогч хүч бөгөөд улсын ба хөдөлмөрчдийн олон түмний бүх байгууллагын манлайлагч бөгөөд жолоодогч гэсэн хуулиар заасан эрх, үүргээс татгалзах хүсэлтээ БНМАУ-ын Ардын Их Хуралд уламжилсан байв. Уг хүсэлтийг 1990 оны гуравдугаар сарын 21-ний өдөр хуралдсан Ардын Их Хурлын чуулганаар хүлээн авч, дээрх заалтуудыг хүчингүй болгохын хамт Үндсэн хуулийн 82 дугаар зүйлд “БНМАУ-ын иргэд хүмүүнлэг ардчилсан иргэний нийгмийг байгуулах зорилт, ард түмнийхээ язгуур эрх ашиг, эв нэгдэлд нийцсэн мөрийн хөтөлбөр, дүрэм бүхий улс төрийн нам, олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэсэн шинэ заалтыг оруулжээ.

Ингээд МАХН-ын Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч тэр үеийн БНМАУ-д олон намын тогтолцоо үүсэн бий болох нөхцөл бүрэлдсэн ч улс төрийн намуудын тухай анхны хууль энэ үйл

*** Ж.Ядамсүрэн “МАХН-ын шинэ мөрийн хөтөлбөр, дүрмийг боловсруулахад 15 эрдэмтний гүйцэтгэсэн үүрэг, намын үзэл баримтлалын зарим асуудалд” илтгэл

* Г.Очирбат – 1990.03. ? -аас 1990.04.13-ыг хүртэл МАН (тэр үедээ МАХН нэртэй байсан)-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, 1990.04.13-аас 199....-ыг хүртэл Төв Хорооны даргаар ажиллаж байв.

явдлаас тун удалгүй батлагдсан гарсан юм. Намын хамт олны шаардсан, хүлээсэн онц их хурлыг хуралдуулах шийдвэрийг Бүгд хурлаас гаргаж, 1990 оны дөрөвдүгээр сарын 10-ны өдөр их хурлыг нээхээр тогтлоо.

Хоёр. Онц их хурлаар хэлэлцсэн, шийдвэрлэсэн асуудлуудын тухайд:

Онц их хурлаар “Өөрчлөн байгуулалтыг гүнзгийрүүлж, МАХН-ыг шинэчлэх ойрын зорилтын тухай” улс төрийн илтгэл, МАХН-ын Мөрийн хөтөлбөр, МАХН-ын Дүрэм, МАХН-ын төлөөлөн удирдах төв байгууллагуудыг сонгох гэсэн дөрвөн үндсэн асуудлыг хэлэлцсэн байдаг. Онц хурал намын мөрийн хөтөлбөр болон дүрэмд иж бүрэн өөрчлөлт хийснээс гадна “улс орны өмнө тулгарсан ойрын зорилтыг шийдвэрлэхэд МАХН-аас баримтлах үндсэн чиглэлийн тухай”, мөн “МАХН-ыг шинэчлэх зорилтын тухай” гэсэн тогтоолуудыг гаргаж, 1990 оны арван нэгдүгээр сард хуралдуулахаар төлөвлөсөн МАХН-ын ээлжит XX их хурлын товлосон хугацааг хойшлуулах, мөн комисс байгуулан ажиллуулах тухай тогтоолыг баталжээ.

Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Г.Очирбатын онц хуралд хэлэлцүүлсэн улс төрийн илтгэл бол тухайн цаг үеийн нөхцөл байдалд тус намын удирдлагаас баримталж байсан бодлогыг тодорхой илэрхийлсэн, улс оронд нэгэнт өрнөсөн шинэчлэл өөрчлөлтийн үйл явцыг түргэтгэхийг зорьсон, намынхаа улс төрийн бодлого, хөтөлбөр болон дүрмийн агуулга, зорилт, зарчимд эрс өөрчлөлт хийх хувилбарыг тайлбарлан дэвшүүлсэн дэвшилтэт байр суурь болсон юм. Тэрхүү илтгэл нь улс орны нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санааны хүрээнд бүрэлдэн бий болсон нөхцөл байдлыг тал бүрээс нь шинжлэн үзэж, түүнд улс төрийн төрийн дүгнэлтөгсөн нэгдэх хэсэг, ардын хувьсгалаас хойш төрийг болон улс орны бүх л асуудлыг удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин болж ирсэн МАХН-ын өмнө тулгамдсан бодлогын зангилаа асуудлуудыг учиг шалтгаан, гарц шийдлийн хамтаар тусгасан хоёр дахь

хэсэг, улс төрийн олон нам бүхий төрийн шинэ тогтолцоонд МАХН өөрийгөө хэрхэн шинэчилж, цаашид оршин тогтнох үндсийг тавих агуулгыг тээсэн шинэ дүрэм, мөрийн хөтөлбөрийн өөрчлөлтийн агуулгыг тусгасан гурав дахь хэсэг гэсэн гурван хэсгийг өөртөө багтаажээ. Онц хурлын улс төрийн илтгэлээс улс оронд үүсээд байсан тэр үеийн нөхцөл байдал болон улс төрийн орчин тэр дундаа МАХН-д тулгамдсан асуудлуудыг танин мэдэх бүрэн боломжтой юм.

Улс төрийн илтгэлд “эдүгээ улс оронд бий болсон нөхцөл байдал болон намын үйл ажиллагааг тал бүрээс нь шүүн хэлэлцэж, намыг тууштай шинэчлэх, өөрчлөн байгуулалтыг гүнзгийрүүлэх зорилго, арга замыг тодорхойлох онцгой хариуцлага тус их хурлын төлөөлөгч та бидэнд ногдож байна” гэж тэмдэглэсэн нь онц их хурлын зорилгыг бэлхнээ тодорхойлжээ. Хөдөлмөрчдийн улс төр, нийгмийн идэвх санаачлага өрнөж ардчилал, ил тод байдлын уур амьсгал орж, хүнд суртал, хөшингө байдлын мөс хайлж эхэлсэн явдал өөрчлөн байгуулалтын анхны үр дүн гэдгийг ч хүлээн зөвшөөрчээ.

Их хурлаас сар орчмын өмнө сонгогдсон МАХН-ын удирдлагууд нийгэм, улс төрийн хямралт байдлын талаар тэмдэглэхдээ намынхаа алдаа дутагдлыг ч гээгдүүлсэнгүйгээр барахгүй дараах байдлаар дүгнэжээ. Энэ нь нэгд, өөрчлөн байгуулалтыг бусад улс оронд нэгэнт өрнөсөн зүй тогтол гэж намын удирдлага хүлээн аваагүйгээс улбаалж 1984 оны VIII бүгд хурлаас хойших бүх л хурал, зөвлөгөөнүүд өмнө явуулж байсан намын бодлогоо хэвээр хадгалах, зарим алдаа дутагдлыг засах гэсэн ерөнхий ярианаас хэтрээгүй; хоёрт, өөрчлөн байгуулалт зайлшгүй болсон гэдгийг нэгэнт ойлгосны дараа л буюу 1988 оны V бүгд хурлаас улс төрийн системийг шинэчлэх зарим санааг дэвшүүлсэн боловч түүнийгээ түргэн шуурхай ажил болголгүй тунхаг хэвээр үлдээсэн нь иргэдийн бухимдлыг бий болгоход хүргэсэн; гуравт, ард түмний улс төрийн идэвх ихээр өрнөсөн шинэ нөхцөлд МАХН ард түмэнтэйгээ улам ойртож, нягтран ажилалгүй хүнд суртлын тогтолцоогоо үргэлжлүүлэн хадгалсан;



дөрөвт, намын удирдлага идэвхгүй байр суурь баримталж байсны улмаас нам, улсын боловсон хүчний нэлээд хэсэг нь нийгмийн шинэ үзэгдэлд гол төлөв хориглон хамгаалсан шинжтэй байсан гэж илтгэлд тусгажээ (Очирбат).

Өөрчлөн байгуулалтын дуудлагаар хуралдсан онц их хурал улс орны өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхдээ шинэчлэлийг нийгмийн бүхий л салбарт буюу эдийн засаг, оюун санаа, байгаль орчин, гадаад бодлого, улс төрийн хүрээнд цогцоор явуулахыг эрмэлзэж байжээ. Энэхүү эрмэлзэл нь улс төрийн илтгэл болон намын шинээр батлагдсан мөрийн хөтөлбөр, их хурлаас баталсан зарим тогтоолд зарчмын цоо шинэ өөрчлөлтүүд тусгагдсан байгаагаас тод харагдана.

Нийгэм, эдийн засгийн хүрээний бодлогыг шинээр тодорхойлохдоо “нийгмийн анхаарлын төвд хүнийг байлгасан хүн ам зүйн бодлого хэрэгжүүлэх”, “улс орныг хөгжүүлэх стратегийн шугамын асуудлаар зөв дүгнэлт хийх”, “төрийн зохицуулалт бүхий зах зээлийн эдийн засагт шилжих”, “өмчийн олон хэлбэр, төрөл чөлөөтэй хөгжих бололцоо, хууль эрхийн баталгааг бий болгох”, “тэтгэвэрийн хэмжээг нэмэгдүүлэхийн хамт зарим шинэ нэр төрлийн тэтгэвэрийг бий болгох”, “хүн амаас авдаг татварыг хянан үзэж, эхнэргүй, нөхөргүй, хүүхэдгүй зэрэг татварыг цуцлах”, “зарим зээлийн хүүг бодохгүйгээр 2000 оныг хүртэл төлөлтийг хойшлуулах”, “иргэдийн амины мал өмчтэй болох боломжийг бүрдүүлэх”, “хөдөөг цахилгаанжуулах ажлыг эрчимжүүлэх”, “телевизийн үндэсний нэвтрүүлэг үзэх боломжийг 1991-1992 онд багтаан төвлөрсөн газар бүрт бий болгох”, “орон сууцны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлэх” зэрэг зорилтыг дэвшүүлсэн байна.

Иргэдийн оюун санааны амьдралын хүрээний шинэчлэлийн бодлогыг “нийгмийн ухамсар, бүтээлч сэтгэлгээ, олон нийтийн санал бодлыг хэв загвараас чөлөөлөх”, “олон ургальч үзлийг бүх талаар дэмжин хөгжүүлэх”, “хэвлэлийн хууль шинээр баталж бие даалган ажиллуулах”, “үндэсний

хэл бичгээ сэргээж, хоёр хэлт улс болох”, “урлаг, соёлын салбарыг өөрийнх нь жам ёсны хуулиар хөгжүүлэх”, “сүм хийдийг хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагааг нь явуулах боломжийг бүрдүүлэх”, “иргэний шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хүндэтгэх”, “гадаад улс орон дахь монголчуудтайгаа хэлхээ холбоогоо хөгжүүлэх”, “эх оронч, иргэний ухамсарт төлөвшлөөр хүн амаа хүмүүлэх”, “аль нэг улс үндэстний эсрэг үзэл суртал явуулахгүй байх” зэрэг зорилтыг дэвшүүлжээ.

Гадаад бодлогын хүрээнд БНМАУ бүрэн биеэ даасан гадаад бодлогоор аливаа улс гүрэнтэй улс төр, нийгэм-эдийн засгийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан олон улсын түгээмэл зарчмын үндсэн дээр эрх тэгш, харилцан ашигтай, идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхийг МАХН дэмжиж ажиллахын зэрэгцээ хуучин социалист орнуудтай найрсаг хамтын ажиллагаагаа хадгалах, хөрш ЗХУ (хуучин нэрээр) болон БНХАУ-тай тал бүрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, өрнөд болон Ази, Номхон далайн улс орнуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх, эвсэлд үл нэгдэх, цөмийн зэвсэг ашиглахгүй байх, ямар нэг улсын эсрэг аль нэг улс, эвслийн цэргийн техник, зэвсэгт хүчинг газар нутагтаа байршуулахгүй байх, МАХН-аас коммунист, хувьсгалт ардчилсан болон социалист, социал-демократ нам, түүнчлэн улс төрийн бусад нам, хөдөлгөөнтэй эрх тэгш хамтарч ажиллах болно гэдгээ илэрхийлжээ.

Улс орны улс төрийн тогтолцоог шинэчлэх тухайд ард түмний бүрэн эрхийн баталгаа болсон хууль цаазат төр байгуулах явдал бол МАХН-ын бодлогын цөм гэдгийг дурдаад “төрийг цөмөө болгосон улс төрийн тогтолцоо бүрдүүлэх”, “засаглалын хуульчлан зохицуулах, гүйцэтгэн захирамжлах, шүүн таслах байгууллагын ажил үүргийн ялгааг зааглах” (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал), “төрийн бүтцийн нэгдмэл тогтолцоог хадгалах”, “байнгын ажиллагаатай ардын төрийн байгууллага (энэ нь эхлээд УБХ дараа нь УИХ болсон), ерөнхийлөгчбүхийтөрийнтогтолцоогчөлөөт сонгуулиар бүрдүүлэх”, “төрийн эрх барих байгууллага буюу АИХ-д намууд мөрийн

хөтөлбөр дэвшүүлэн оролцож, төлөөллөө сонгуульдаг болох”, “нийгмийн харилцааны хуульзүйн үндсийг бүхэлд нь шинэчлэн боловсронгуй болгох”, “улс төрийн нам, эвсэл, холбоодын эрх тэгш байдал, хамтын ажиллагаа, чөлөөт өрсөлдөөнийг дэмжих” зэрэг зорилтыг тодорхойлсон байна.

Дээр дурдсан нийгэм, эдийн засаг, оюун санаа, гадаад бодлого, улс төрийн хүрээний шинэчлэлийн үзэл санаа нь онц их хурлаас гуравхан сарын дараа болсон Ардын Их Хурлын сонгуулиар биежиж, тэндээс байгуулагдсан байнгын ажиллагаатай Улсын Бага Хурлаас боловсруулсан 1992 оны Үндсэн хуульд тусгалаа олсон юм.

Нэгэнт олон намын тогтолцоог хуульчилж, төрийг нам удирдах хуулийн заалтыг хасаж, бусад шинэ тутам намуудтай ижил тэгш харилцаанд орохоо илэрхийлсэн тухайн үеийн МАХН-ын өмнө өөрийгөө шинэчлэх асуудал нэн тэргүүний сорилт байлаа. Тийм ч учраас тэр үеийн намын удирдлагуудын өмнө намаа улс төрийн шинэ орчинд унагачихалгүй зохицуулан авч үлдээх гэсэн хичээл зүтгэл, намын жирийн олон мянган гишүүдийн өмнө шинэчлэлд дасан зохицох сэтгэлийн зовнил ихэд байсан нь онц их хурлын уур амьсгал, төлөөлөгчдийн хэлсэн үг, баталсан баримт бичгүүдэд илэрхий байна. МАХН-ын Төв Хорооны даргын тавьсан улс төрийн илтгэлийн хоёрны нэг нь намыг шинэчлэх гол чиглэлд анхаарч, их хуралд оруулж батлуулсан “МАХН-ыг шинэчлэх зорилтын тухай” тогтоол нь намын шинэчлэлийн мөн чанарыг агуулжээ.

МАХН-ыг “Монголын ард түмний язгуур эрх ашгийг илэрхийлэн хамгаалах, тусгаар тогтнол, үндэсний эв нэгдлийг сахин бэхжүүлэх, БНМАУ-д хүнлэг, ардчилсан социалист нийгэм байгуулахын төлөө тэмцэгч улс төрийн байгууллага” гэж шинэ мөрийн хөтөлбөрт тодорхойлоод “шинэ мөрийн хөтөлбөр, дүрмийн дагуу онол, үзэл суртал, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, арга барилыг ардчиллын үндсэнд нийцүүлэн яаралтай өөрчлөх”, “гишүүд, дэмжигчид боловсон хүчнийхээ мэдлэг чадварыг дээшлүүлэх”, “намын аппаратыг улс төрч, зарчимч, хөнгөн шуурхай болгож

цомхотгох”, “ардчилсан социализмын үнэт зүйлсийг нийгмийн ухамсарт шингээхэд чиглүүлэх”, “түүхэн бодит үнэнд нийцүүлэн МАХН-ын түүхийг шинэчлэн бичих”, “бүх шатны ардын хурлуудад бэлтгэж, оролцох мөрийн хөтөлбөрийг өргөн хүрээнд боловсруулах”, “нам өөрийгөө санхүүжүүлэхэд бэлтгэх”, “намын хяналтын байгууллагыг жинхэнэ утгаар нь ажиллуулах”, “намын хэвлэл нь үнэн зөв мэдээллийг хүргэж, нам болон олон нийтийн харилцааг ойртуулах” гэсэн байдлаар намын шинэчлэлийн ойрын зорилтыг томъёолжээ.

Өмнө дагаж мөрдөж байсан дүрмийг халж, улс төрийн шинэ нөхцөлд нийцсэн дүрмийг онц их хурлаас баталсан юм. Гучин дөрвөн жилийн зайтай батлагдсан хоёр дүрмийн хооронд нэлээд олон зарчмын өөрчлөлт гарсан байдаг. Энэ нь судлаачийн байрнаас харахад анхаарал татахгүй байх аргагүй судалгааны асуудал ажээ. Дүрмийн өөрчлөлтийн талаар товч дурдая.

Намын шинэ дүрэмд МАХН-ын эрхэм зорилгыг “Хөдөлмөрчдийн сайн сайхан байдал, хүний чөлөөт хөгжлийг хангах” гэж тодорхойлоод нам үйл ажиллагаандаа марксист-ленинист үзэл санаа, арга зүйг бүтээлчээр хөгжүүлэн хэрэгжүүлнэ гэж заажээ. Шинэ дүрэм нь оршил хэсгээс гадна “МАХН-ын гишүүн, түүний эрх, үүрэг”, “МАХН-ын зохион байгуулалтын бүтэц, дотоод ардчилал”, “Монгол Ардын Хувьсгалт Нам ба бусад байгууллага”, “Намын хөрөнгө” гэсэн дөрвөн бүлэг, 50 зүйлээс бүрдэж байв.

Аливаа улс төрийн нам, хүчний амин сүнс, хөдөлгөгч хүч бол гишүүд байдаг. Тиймээс энэ дүрэмд ч гишүүдийн асуудлыг нэн түрүүнд авч үзжээ. Өмнөх дүрмээр намын гишүүн болох амаргүй байв. Гишүүнээр элсэхийг хүсэгч нь намын хоёр гишүүнээр батлан даалгадаг, зургаан сарын хугацаанд орлогч гишүүний статустай явдаг, намын жинхэнэ гишүүн болох асуудлыг намын үүр хэлэлцэх боловч эцсийн шийдвэрийг аймаг, хотын намын хороо, зарим хүний асуудлыг Хянан шалгах хороо тусгайлан хэлэлцдэг байжээ. Тэгвэл шинэ дүрмээр 18 нас хүрсэн БНМАУ-ын иргэн хэний ч өмнө намын гишүүнээр элсэх үүд хаалга нээлттэй болж,



элдэв шалгуурт болзлыг байхгүй болголоо. Намын гишүүнд элсүүлэх, гишүүнээс хасах асуудлыг намын үүр бие даан “эцэслэн шийдвэрлэх” эрхтэй болов. Гишүүний эрх, үүргийн тухайд өмнөх дүрэмд гишүүний эрх хязгаарлагдмал, харин үүргийг нэлээд анхаарч оруулсан байсан бол шинэ дүрмээр гишүүний намд хүлээх үүрэг цөөрч, эдлэх эрх нэмэгдсэн. Тухайлбал, гишүүн нь намын бодлого хэлэлцэхэд оролцох, хурал дээр намын гишүүнийг шүүмжлэх, намын удирдах байгууллагад сонгогдох болон сонгох, өөрийн тухай шийдвэр гаргах үед биечлэн оролцох гэсэн дөрвөн зүйл эрхтэй байсан бол намын удирдах байгууллагад нэрээ дэвшүүлэх болон татгалзах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр намын аль ч байгууллага, гишүүнийг шүүмжлэх, өөрт оногдсон зэмлэлийг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад хандах, намын бодлого боловсруулахад оролцох, намын байгууллагаас тусламж дэмжлэг авах зэрэг долоон зүйл болж өргөжсөн байна. Өмнөх дүрмээр намын гишүүн нь есөн зүйл үүрэг хүлээдэг байсан бол шинэ дүрэмд намаас өгсөн үүргийг биелүүлэх, намын эв нэгдлийг хамгаалах үүрэг уламжлан үлдэж, шинээр намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, намын гишүүд, дэмжигчдийн хүрээг өргөтгөхөд санаачлага гаргах, өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх, үнэнч шударга, хүнлэг зарчмыг баримтлах, намын сан хөмрөгийг өргөжүүлэхэд хувь нэмрээ оруулах гэсэн зургаан зүйл болжээ.

Намын дүрмийн шинэчлэлийн хүрээнд намын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт хийх нь зайлшгүй байлаа. Өмнө нь улс орны эд эс бүхэнд оролцож байсан нам шинэ дүрмээр зөвхөн нутаг дэвсгэр болон үйлдвэрлэлийн шинжээр зохион байгуулагдах болов. “Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим нь өмнөх дүрмээр төвлөн удирдах зарчмыг хэрэгжүүлж байсан бол шинэ дүрмээр ардчилсан нэгдлийн зарчим баримтлахаар заасан байна (Монгол ардын хувьсгалт нам, 1990). Намын ажлын бүтэц, арга барил нь дээрээс доош захиргаадан тушаах хэв маягтай явж ирсэн бол шинэ дүрмийн

бүтцээр асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, нийтийн болон олонхи гишүүдийн эрх ашигт нийцүүлэн гаргах, намын дээд шатны байгууллагын шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл доод шатны байгууллага нь эргэж харахыг шаардах, цөөнх өөрийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл дээд шатны байгууллагад хандах, нийтээр гаргасан шийдвэрийг бүгд дагаж мөрдөх, боловсон хүчний нөөцийг төвлөрүүлэн бус шат шатандаа бүрдүүлэх зэрэг дотоод ардчиллын асуудлыг шинэ дүрэмд гүнзгий тусгажээ. Намын дээд байгууллагыг Төв Хороо нэрээр нь хэвээр үлдээж, харин Улс төрийн товчоог Төв Хорооны тэргүүлэгчид гэж нэрлэхээр болжээ. Намын Төв Хороо болон Улс төрийн товчоонд орлогч гишүүн гэж хуучин байсныг шинэ дүрэмд оруулсангүй. Төв Хороо нь өмнөх дүрээр Их хурлын чөлөө цагт бүх удирдах эрхийг эдэлдэг байсан бол шинэ дүрмээр Их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхэд үндсэн ажлаа чиглүүлэх болжээ. Энд нэг зүйлийг зориуд онцлон дурдахад намын шинэ дүрмийн 34 дүгээр зүйлд байх “Шаардлага гарвал МАХН-ын бага хурлыг Намын Төв Хорооноос зарлан хуралдуулж болно” гэсэн заалт хэрэгжээгүй явсаар Бүгд хурал нь хожмоо Бага хурал хэмээн нэрлэгдэх болсон (Даш-Ёндон, 2010, х 57). Тус дүрмээс харахад уг заалт дахь бага хурал гэгч нь чухам ямар статустай болох, ямар асуудлыг эрхлэн шийдэх талаар илүү дэлгэрэнгүй юм алга.

Хувьсан өөрчлөгдөж буй цаг үетэйгээ хамт халаагаа өгсөн хуучин дүрэмд “Нам ба Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл”, “Ардын цэргийн доторх намын байгууллагууд”, “Нам бус байгууллагууд дахь намын хэсэг” нэртэй бүлгүүд онц их хурлын өмнө өрнөсөн шинэчлэлийн үйл явдлууд болон намын өөрчлөлтийн бодлоготой уялдан гээгдэж, оронд “МАХН ба бусад байгууллага” гэсэн зургаан зүйлт бүлэг шинэ дүрэмд орсон юм. Ингэснээр Монголын хувьсгалт залуучуудын эвлэл, Ардын цэргийн улс төрийн газар зэрэг намын шууд удирдлагын байгууллага дүрмээр байхгүй болж оронд МАХН-аас бусад төрийн болон төрийн бус байгууллага,

эвлэл, холбоодтой хууль, журмын дагуу улс төрийн аргаар харилцах зайлшгүй шаардлага бий болсон юм.

Өмнөх дүрэмд байсан намын Төв Хорооны дэргэдэх Намын хянан шалгах хороо болон Намын төв шалган байцаах комисс хоёрыг шинэ дүрмээр нэгтгэж, Намын хянан шалгах төв комисс гэж нэрлэн эрх, үүргийн хүрээг нь намын зохион байгуулалт талаас өргөжүүлж, бие даан ажиллах боломжоор хангаж өгчээ. Харин улс орны хэмжээний асуудалд салбар үл хамааран хутгалддаг байдлыг Үндсэн хуульд орсон шинэ өөрчлөлтийн агуулгад нийцүүлэн байхгүй болгосон юм. Намын дүрмийн 40 дүгээр заалтын дагуу “намын дүрэм хөтөлбөрт хяналт тавих, намын гишүүдийн гомдол, санал, өргөдлийн хэрэгжилтийг хянах, дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, намыг хуурч мэхлэх болон дур зоргоороо авирлах явдалтай тэмцэх, аймаг хотын намын хянан шалгах комисстой холбогдох гомдлыг хянаж шийдвэрлэх, үйл ажиллагаагаа ил тод байлгах, намын хөрөнгө санхүүд хяналт тавих” гэсэн зургаан эрх, үүргийг хүлээлгэжээ.

Намын санхүүжилтийн тухайд намын гишүүдийн татварын мөнгөн орлогоос гадна төрийн эрх баригч намын хувьд улсын төсвөөс зохих хэмжээний санхүүжилт авч байсныг болиулж, шинэ дүрмийн дагуу нам өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжсэн байдаг.

1966 оны зургаадугаар сард хуралдсан МАХН-ын XV их хурлаас баталсан намын программ буюу мөрийн хөтөлбөр, дүрмийг тасралтгүй 34 жил дагаж мөрдсөөр 1990 онд ийнхүү иж бүрэн өөрчлөлт хийсэн юм. Энэ мөрийн хөтөлбөр, дүрэм нь нийгмийн сэтгэлгээний өөрчлөлтийн эрчимтэй давалгаа, шинэчлэлийн хүч түрсэн үйл явдлууд, улс төрийн шинэ орчинд тухайн үеийн МАХН, түүний олон мянган гишүүдийг дасан зохицох, оршин үлдэхэд чухал хувь нэмрээ оруулсан гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Онц их хурлын онцлох нэг үйл явдал бол хурлын төлөвлөгөөнд огт ороогүй ч хурлын сүүлчийн өдөр их хурлын

төлөөлөгчдийн санаачилгаар Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн үйл ажиллагаанд улс төр, ёс зүйн дүгнэлт өгөх, намын хариуцлага ногдуулах асуудлыг тухайлан хөндөж, энэ асуудлаар ажлын хэсэг буюу комисс байгуулсан хэрэг юм. Түүхч, дэд эрдэмтэн Б.Сумъяагаар ахлуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй комисс ажлаа тус оны хоёрдугаар улиралд багтаан гүйцэтгэж, намын Төв Хороонд танилцуулах үүргийг хүлээжээ. 1990 оны зургаадугаар сарын сүүлчээр хуралдсан Төв Хорооны III бүгд хуралд тус комисс тойрон хүрээлэгчдийн талаар бэлтгэсэн саналаа оруулж, дүгнүүлээд тогтоолын дагуу татан буусан байна. Комиссоос “бүхнийг сайн сайхан мэтээр сурталчилж байсан, зөвхөн нэг хүнд нийцүүлэн бүх асуудлыг шийддэг байсан, боловсон хүчний сонголтонд зөвхөн орос хэлний мэдлэгийг төвийлгөж, захиран тушаах дэглэмд үнэнч байсан, намын бодлогод онолын сэтгэлгээг үл ойшоосон, Цэдэнбалын гэргийг төрийн асуудалд хутгалдуулсан, эрх мэдлээ хэтрүүлсэн” зэрэг зургаан үндэслэлээр нийт 41 хүний үйл ажиллагаанд улс төр, сахилга, ёс зүйн үнэлэлт өгч долоон хүнийг намаас хасах, зургаан хүнийг намаас хасахыг сануулж зэмлэх шийтгэлийг бүгд хурлаас гаргажээ.

Энэ үйлдэл нь онц их хурлын өмнө хуралдсан VIII бүгд хурлаас үүдэлтэй бөгөөд тус хурал Ю.Цэдэнбалыг “...нам, ард түмний үйл хэрэг, нийгмийн шударга ёсонд ихээхэн хор уршиг тарьсан” гэж тэмдэглэж байжээ. Нийгмийн уур амьсгал нам, төрийн удирдагчдад нэн тааламжгүй хандах болсны зэрэгцээ “ард түмний онцгой зөвлөл” байгуулахыг шаардаж байсан нь тэр үеийн МАХН-ын удирдлагаас нийгмийн сэтгэл зүйг тайвшруулах үйлдэл хийх, цаашлаад онц их хурлаас тусгай комисс байгуулах байдалд хүргэсэн байхыг ч үгүйсгэх аргагүй юм. Тус комиссыг байгуулах үед намын удирдлагын зүгээс өөрөө хэлмэгдэж байсан эсвэл хэн нэгнийг хэлмэгдүүлж байсан хүмүүсээс комисст оруулахгүй байхыг зөвлөсөн нь байдлыг хүндрүүлэхгүй байхад том түлхэц болжээ. Комиссын ажлыг зохион байгуулах амаргүй байсан ч



нийгмийн шаардлага, намын дүрэм, журмын дагуу комиссын бүрэлдэхүүн ажилласан гэдгийг комиссын ахлагч Б.Сумъяа 2010 онд онц их хурлын 20 жилийн ойн хурал дээр хэлсэн үгэндээ тэмдэглэсэн байдаг (Сумъяа, 2010, х.69). 1997 онд хуралдсан XXII их хурал Ю.Цэдэнбалд ногдуулсан намын шийтгэлийг арилгаж, 2001 онд хуралдсан XXIII их хурлаас байгуулагдсан Бага хурал Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчид хэмээгдэгчдэд оногдуулсан шийтгэл, зэмлэлийг арилгасан. Ер нь энэхүү Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчид гэгдэгчид болон тэдэнд хариуцлага тооцох комиссын үйл ажиллагаа, комисс байгуулах болсон түүхэн шалтгаан, цаашид үргэлжлэн гарсан улс төрийн үр дагаварын талаар тусгайлан судлах хүлээлт, орон зай улс төрийн түүх судлаачдын дунд байсаар байна.

Онц их хурал зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, шинэ дүрмийнхээ дагуу намын Төв Хороог 91 хүний бүрэлдэхүүнтэйгээр, харин намын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх хоёр байгууллагыг нэгтгэсэн Хянан Шалгах Төв Комиссыг 31 гишүүнтэйгээр тус тус байгуулав. Их хурал хаасны дараа буюу 1990 оны дөрөвдүгээр сарын 13-ны өдөр хуралдсан намын Төв Хорооны анхдугаар хурлаас МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгч гишүүнээр Г.Очирбат, Н.Мишигдорж, Ц.Өөлд, Б.Сумъяа, Ц.Гомбосүрэн, Л.Түдэв нарыг, МАХН-ын Төв Хорооны даргаар Г.Очирбатыг, Төв Хорооны Нарийн бичгийн даргаар Н.Мишигдорж, Ц.Өөлд, Б.Сумъяа нарыг, МАХН-ын төв хэвлэл “Үнэн” сонины эрхлэгчээр Л.Түдэвийг тус тус сонгож батласан байна.

Гурав. Онц их хурлын үр дүн, ач холбогдлын тухайд:

Түүхэнд ганц удаа болсон МАН-ын онц их хурлын үр дүн, түүний ач холбогдлыг олон талаар тайлбарлаж болох боловч нэгд, улс оронд өрнөсөн өөрчлөн байгуулалтыг түргэтгэхэд тухайн үеийн эрх баригч улс төрийн хүчний хувьд үүргээ ухамсартайгаар хэрэгжүүлсэн; хоёрт, улс төрийн олон намын тогтолцоог бүрнээр

хүлээн зөвшөөрч, намын шинэчлэлийн үзэл баримтлалаа батлан гаргаж, түүнийгээ тууштай хамгаалах, хэрэгжүүлэхийн тулд намаа дахин бүртгүүлж, улс төрийн эрс шинэ орчинд бусад намуудтай адил эрх хэмжээ эдлэх болсон; гуравт, онц хурлаас дэвшүүлсэн нийгэм, эдийн засаг, гадаад харилцаа, байгаль орчны шинэчлэлийн бодлого нь өргөн цар хүрээг хамарч улс орны ойрын төлөвлөгөө болон хэрэгжиж, улмаар чөлөөт өрсөлдөөнт эдийн засагтай болох, иргэний чөлөөтэй сэтгэх, үзэл бодлоо илэрхийлэх, бишрэн шүтэх эрх чөлөөт нөхцөлийг бүрдүүлэн иргэн төвт нийгэм байгуулах үндэс суурь болсон; дөрөвт, улс төрийн тогтолцоо (систем)-г бүрэн өөрчилж, төрийн бүтцийн байгууламж, засаглалын шинэ бодлого хэрэгжүүлсэн нь ард түмний төлөөллийг хангасан, байнгын ажиллагаатай шинэ парламент байгуулах, ерөнхийлөгч тэргүүтэй төрийн шинэ бүтэц хийх, цаашлаад шинэ Үндсэн хууль батлагдах суурь нөхцөлийг бүрдүүлсэн гэдгээр дүгнэж болно.

Улс төрийн шинэчлэлийн нэг онцлог бол олон намын тогтолцоо бүрэлдсэн явдал байв. Энэ дагуу онц их хурлын дараа буюу 1990 оны тавдугаар сард БНМАУ-ын дээд шүүхэд намаа шинэчлэн бүртгүүлэх ажлыг тэр үеийн МАХН-ын Төв Хорооноос зохион байгуулж, мөн оны долоодугаар сард Ардын арми, Улсыг аюулаас хамгаалах ерөнхий газар, Улсын цагдан сэргийлэх байгууллагууд дахь намын бүтцийн үйл ажиллагааг зогсоож, намын үүр буюу анхан шатны нэгжүүдээ үйлдвэр болон бусад газруудаас шилжүүлэн нутаг дэвсгэрийн зарчмаар байгуулж, бүх шатны намын байгууллагын аппаратын орон тоог 50 гаруй хувиар цомхотгож, намын бүх байгууллага өөрөө санхүүжих зарчимд шилжиж, мөн оны хавар батлагдсан “Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль”, “Улс төрийн намуудын тухай хууль”, “АИХ-ын сонгуулийн тухай хууль” зэрэг шинээр мөрдөж эхэлсэн хууль, тогтоомжуудын хэрэгжилтэнд саад болохуйц хуучин хууль, дүрэм, журмыг хүчингүй болгох болон шинэчлэх ажлыг ээлж дараалан тасралтгүй явуулсан. Энэ үйл явдал 1990, 1991 оны турш өрнөсөн бөгөөд 1992 оны шинэ

Үндсэн хуулинд шинэчлэл, өөрчлөлтийн үзэл санаагаа тусгасан юм.

Онолын сэтгэлгээг хөгжүүлэх явдал нийт нам, улмаар улс орны өөрчлөн байгуулалтын нэг нэн чухал зорилт гэж үзсэнийхээ дагуу эрх мэдэл, албан тушаалын хуваарилалтаас илүү намаа шинэчлэх, улс орноо шинэ замаар өөрчлөн байгуулах эрмэлзэл тэр үеийн нам, төрийн удирдагчдад дүүрэн байжээ. МАН-ын удирдлагууд ардчилал, шинэчлэлийг тууштай дэмжиж байсан нь онц их хурлын дараахан буюу 1990 оны долоодугаар сард болсон Ардын Их Хурлын төлөөлөгчдийг сонгосон сонгууль, Ардын Их Хурлаас Улсын Бага хурлыг байгуулан төр засгийн удирдах албан тушаалд тэр үеийн МАХН-ын удирдлагууд өөрсдийгөө биш харин өөр хүмүүсийг, тэр дундаа шинэчлэл өөрчлөлтийг шаардсан нам, эвслүүдийн дундаас томилсон байгаагаас шууд батлагддаг.

Тэр үед МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргаар Г.Очирбат, намын төв хэвлэлийн эрхлэгчээр Л.Түдэв, нарийнбичгийн дарга Н.Багабанди, Б.Сумъяа, Ж.Болдбаатар нар ажиллаж байсан боловч АИХ-ын дарга буюу төрийн тэргүүнээр П.Очирбат (МАХН), Сайд нарын зөвлөлийн дарга буюу ерөнхий сайдаар Д.Бямбасүрэн (МАХН), УБХ-ын даргаар Р.Гончигдорж (МСДН), тэргүүн шадар сайдаар Д.Ганболд (МҮДН), шадар сайдаар Д.Дорлигжав (МоАН), Ч.Пүрэвдорж (МАХН), УБХ-ын орлогч даргаар З.Зардыхан, УБХ-ын нарийн бичгийн даргаар Б.Чимэд нарыг сонгож байв. Сонгуулийн дүнгээр сонгогчдоос нэг хувийн санал авч, АИХ-д дөрөв, УБХ-д гурван гишүүний төлөөлөлтэй болсон МСДН-ын даргыг УБХ-ын дарга, АИХ-д 16 ба зургаа, УБХ-д 13 ба гурван суудал авсан МоАН ба МҮДН-уудын төлөөллийг шадар сайдаар ажиллуулж, АИХ-ын төлөөлөгчдийн 87 хувь буюу 367 нь шинээр сонгогдсон нь МАН-ын онц их хурлаас дэвшүүлсэн улс төрийн системийг өөрчлөн байгуулах зорилтын эхний үр дүнгүүд байлаа. Тэр үеийн их, бага хурал болон төр, засгийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага нь үнэт зүйл, үзэл баримтлалын бодит зарчим болж байсныг эл баримт гэрчилнэ.

Төрийн эрхийг удаан жил барьсан эрх баригч нам, шинэчлэл өөрчлөлтийг шаардсан улс төр, нийгмийн бүлгүүдтэйгээ ойлголцож чадсанаар Бээжингийн төв талбайд жагсагчдыг нухчин дарсан шиг, Бухарестад удирдагчаа хөнөөсөн шиг, Москвад төрийн Думын ордон руугаа танкаар буудсан шиг үйл явдал Монголд болсонгүй. Түүхийг “хэрэв...” гэдэг үгээр эргүүлэн шүүх боломжгүй, зарчимгүй боловч тэр үеийн төр, намын удирдагчид болж буй үйл явдлыг эрүүлээр харж, хэрхэн ажиллахаа саруулаар сэтгээгүй бол монголд олон намын тогтолцоо бүрэлдэж, хүний эрхийг бүх талаар хүндэтгэн дээлдэлж, эдийн засгийн чөлөөт зах зээлийг хүлээн авч, улс төрийн тогтолцооны өөрчлөлт явагдаж, хэд хэдэн намын төлөөлөл оролцсон байнгын ажиллагаатай парламентыг бий болгож, шинэ Үндсэн хууль батлахгүй байв.

Харин ч эсрэгээрээ уг хэлсэн иргэдээ хавчиж, хэлмэгдүүлж, хатуу гараар төр иргэндээ төмөр нүүрээ үзүүлж, гадаадын зарим оронд болсон шиг үйл явдал өрнөхийг ч үгүйсгэхгүй байсан олон баримтууд байна. Гэвч эцэст нь тэгсэнгүй. Монгол төрийг удирдагчид нам төвт тогтолцооноос татгалзаж, өөрсдийн саналаар эрх мэдлийн суудлаасаа бууж, эрх баригч намдаа улс төрийн шинэчлэлийг, эх орондоо хөгжлийн өөрчлөлтийг эхлүүлсэн юм.

XX зууны төгсгөл дэх монголын ардчилал хүч үл хэрэглэглэх зарчим, замналаар өөрчлөн байгуулалтыг монголд бий болгосон. Энэхүү үйл явдлыг “Хямралт байдлыг ухаалгаар, эв зүйгээр даван туулах нь улс орны улс төрийн амьдрал төдийгүй нийгмийн амьдралын бүхий л салаа мөчрийг нэг бүрчлэн удирдаж ирсэн МАХН-д өөрийн эрхгүй тулгарчихаад байв. ...Манай намын орших, эс оршихын асуудал ч шийдэгдэхэд хүрээд байсан.

Ийм нөхцөлд 1990 онд хуралдсан намын Төв Хорооны VIII бүгд хурлаар намын удирдлагад сонгогдсон шинэ Улс Төрийн Товчоо зөв гарцыг олж харсан” гэж МАН-ын даргаар ажиллаж байсан Б.Даш-Ёндон онц их хурлын 20 жилийн ойг үеэр тэмдэглэн дүгнэсэн нь зүйд нийцэх юм.



ДҮГНЭЛТ

Түүхийн өнөөгийн цаг хугацаанаас эргэн харахад зарим үйл явдлыг дутуу орхигдуулсан, буруу зохион байгуулсан гэхчлэн буруутгах өнцгүүд байж болох ч тэр цаг үеийн нөхцөл байдалд үндэслэн дэвшүүлсэн “Өнөөдөр намын бүх шатны байгууллагыг идэвхжүүлэх, намын дотор шинэчлэлийн хүчийг нягтруулан олон түмэнд түшиглэх, хамтран ажиллах замаар тэднийг зохион байгуулах арга барилаа эрс өөрчлөх явдал нам, улсад бий болсон төвөгтэй байдлаас гарах гол зам мөн” гэж тодорхойлсон зорилтдоо онц их хурал хүрсэн гэж үзэж болно.

Онц их хурал үндсэндээ намын удирдлагын болон нийт намын түвшинд гаргасан алдаа дутагдалдаа дүгнэлт хийж, нухацтай сургамж авч, нийгмийн сэтгэлгээний өөрчлөлт болон улс төрийн цоо шинэ орчинд оршин тогтнох замналаа эрэлхийлсэн үйл явдал болов.

Эцэст нь онц их хурлын ач холбогдлыг улс орны амьдралд гаргасан эрс өөрчлөлтийн гүнзгий эхлэл, улс төрийн орчинд үзүүлсэн шинэчлэлийн тусгал, МАХН-д бий болгсон хувьслыг юутай ч харьцуулан үнэлэх боломжгүй юм гэсэн нэг өгүүлбэрээр дүгнэж болно.

Энэ бол монголчуудын ХХ зууны төгсөлд хийсэн улс төрийн түүхэн эргэлт байлаа.

эмхэтгэл 2004-2005 он”

Улаанбаатар

Цэвлээ, Х. (2015.08.05) . Цагаан морин жилийн цаад наад учир холбогдол. *Монголын үнэн сонин*, №147

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Батмөнх, (1986). *Илтгэл өгүүлэл хэлсэн үг*. Улаанбаатар

Монгол ардын хувьсгалт нам. (1986). *МАХН-ын XIX их хурал*. Улаанбаатар

Монгол ардын хувьсгалт нам. (1990). “МАХН-ын онц их хурал” хурлын эмхэтгэл. Улаанбаатар

Монгол ардын хувьсгалт нам. (2010). “МАХН-ын онц их хурал, намын шинэчлэл” бага хурлын эмхэтгэл. Улаанбаатар

Прогноз академи. (2005). “Эрдэм шинжилгээний бага хурлуудын